



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/602.

Улаанбаатар хот

「 Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 240,000.00 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэг (Н.Баярцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 240,000.00 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгахыг Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэг (Н.Баярцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа
В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн хариуцаж буй
дартын 2024 оны 1⁻ дугаар
өдрийн А601-дугаар тушаал

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэг

[illegible]